ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/199/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -ы гэрээт аудитор: Б.Цэрэндэжид

Утас: 99218108

Цахим хаяг: Tserendejid1109@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан....13
4.1 Ерөнхий зүйл ....13
4.2 Материаллаг байдал ....14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16
5. Аудитын илрүүлэлт ....16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.28 № 332

танай________-ны №________-т

МОНГОЛ УЛСЫН
КОНСЕРВАТОРЫН
ХАРЬЯА ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ХӨГЖИМ БҮЖГИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
И.ЭНХЗУЛ-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж нь 2024 онд улсын төсвөөс 2,563,037.7 мянган төгрөгийн, нэмэлтээр 70,804.4 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна. Тус байгууллага нь нягтлан бодогчоо тогтвор суурьшилтай ажиллуулж, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 257.0 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тооцож олгосон, дотуур байрны хүнсний материалын үлдэгдэл 443.4 мянган төгрөгөөр дутагдсан, үйлчилгээний ажилчдад 1,800.0 мянган төгрөгөөр ажлын хувцас худалдан авсан, он дамжсан 11,604.55 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.



81 5 495

**Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж нь үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 210 нэр төрлийн 377,515.5 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгаагүй, 2023 онд Швейцарын хөрөнгө оруулалтаар ирсэн хөгжим, аппартур тоног төхөөрөмжийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

# Санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 386,403,986.07 | 354,054,615 |
| 2 | АВЛАГА | 16,537,438.17 | 18,610,775.1 |
| 3 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 4,932,889.77 | 5,623,226.7 |
| 4 | Бусад авлага | 11,604,548.4 | 12,987,548.4 |
| 5 | Байгууллагаас авах авлага | | 1,383,000 |
| 6 | Хувь хүмүүсээс авах авлага | 11,604,548.4 | 11,604,548.4 |
| 7 | БАРАА МАТЕРИАЛ | 369,866,547.9 | 335,443,839.9 |
| 8 | Түүхий эд материал | 213,619,067.9 | 200,346,467.9 |
| 9 | Тусгай зориулалттай материал | 213,234,067.91 | 199,961,467.91 |
| 10 | Эм боох материал | 384,999.99 | 384,999.99 |
| 11 | Хангамжийн материал | 156,247,480 | 135,097,372 |
| 12 | Бичиг хэргийн материал | 19,811,900 | 17,661,600 |
| 13 | Аж ахуйн материал | 127,006,280 | 103,245,760 |
| 14 | Барилгын засварын материал | 65,500 | 460,300 |
| 15 | Хүнсний материал | 443,400 | 965,550 |
| 16 | Бусад хангамжийн материал | 8,920,400 | 12,764,162 |
| 17 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,153,010,658.4 | 2,079,120,940.31 |
| 18 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,153,010,658.4 | 2,079,120,940.31 |
| 19 | Биет хөрөнгө | 2,105,330,658.4 | 1,999,150,940.31 |
| 20 | Барилга, байгууламж, орон сууц | 2,135,624,630 | 2,135,624,630 |
| 21 | Хуримтлагдсан элэгдэл | -311,729,615.92 | -372,833,854.96 |
| 22 | Авто-тээврийн хэрэгсэл | 23,500,000 | 23,500,000 |
| 23 | Хуримтлагдсан элэгдэл | -23,500,000 | -23,500,000 |
| 24 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 552,085,596.87 | 505,870,438 |
| 25 | Хуримтлагдсан элэгдэл | -323,834,772.31 | -329,204,179.05 |
| 26 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 162,983,757.7 | 161,732,393.7 |
| 27 | Хуримтлагдсан элэгдэл | -161,820,756.8 | -155,839,059.98 |
| 28 | Бусад үндсэн хөрөнгө | 8,500,000 | 8,500,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 29 | Хуримтлагдсан элэгдэл | -5,312,499.72 | -6,162,499.68 |
| 30 | Ном | 48,834,318.58 | 51,463,072.28 |
| 31 | Биет бус хөрөнгө | 47,680,000 | 79,970,000 |
| 32 | Програм хангамж | 2,150,000 | 2,150,000 |
| 33 | Хуримтлагдсан элэгдэл | -2,150,000 | -2,150,000 |
| 34 | Бусад биет бус хөрөнгө | 47,680,000 | 79,970,000 |
| 35 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,539,414,644.47 | 2,433,175,555.31 |
| 36 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 34,726,124.08 | 38,793,444.06 |
| 37 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 34,726,124.08 | 38,793,444.06 |
| 38 | Өглөг | 34,726,124.08 | 38,793,444.06 |
| 39 | Ажилчидтай холбогдсон өглөг | 39,904.04 | 11,602,969.06 |
| 40 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 404,365.04 | |
| 41 | Бусад өглөг | 34,281,855 | 27,190,475 |
| 42 | Байгууллагад төлөх өглөг | 29,184,405 | 22,133,025 |
| 43 | Хувь хүмүүст төлөх өглөг | 5,097,450 | 5,057,450 |
| 44 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,504,688,520.39 | 2,394,382,111.25 |
| 45 | Засгийн газрын хувь оролцоо | 2,504,688,520.39 | 2,394,382,111.25 |
| 46 | Засгийн газрын оруулсан капитал | 1,975,612,137.46 | 1,975,612,137.46 |
| 47 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 1,975,612,137.46 | 1,975,612,137.46 |
| 48 | Хуримтлагдсан үр дүн | -270,538,088.58 | -380,844,497.72 |
| 49 | Өмнөх үеийн үр дүн | -161,550,971.97 | -270,538,088.58 |
| 50 | Тайлант үеийн үр дүн | -108,987,116.61 | -110,306,409.14 |
| 51 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 799,614,471.51 | 799,614,471.51 |
| 52 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,539,414,644.47 | 2,433,175,555.31 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

# Санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,060,912,472 | 2,689,326,658.14 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 73,083,472 | 100,429,641.7 |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 73,083,472 | 100,429,641.7 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 71,424,632 | 54,316,000 |
| 5 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 71,424,632 | 54,316,000 |
| 6 | Бусад орлого | 1,658,840 | |
| 7 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 42,231,979.7 |
| 8 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 3,881,662 |
| 9 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,987,829,000 | 2,588,897,016.44 |
| 10 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,982,529,000 | 2,563,037,700 |
| 11 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,982,529,000 | 2,563,037,700 |
| 12 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,300,000 | 25,859,316.44 |
| 13 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,300,000 | 2,287,896 |
| 14 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 23,571,420.44 |
| 15 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,169,899,588.61 | 2,799,409,841.28 |
| 16 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,169,899,588.61 | 2,799,409,841.28 |
| 17 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,000,972,394.83 | 2,651,117,617.93 |
| 18 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,334,256,732.97 | 1,834,826,198.88 |
| 19 | Үндсэн цалин | 1,051,871,762.94 | 1,217,075,610.55 |
| 20 | Нэмэгдэл | 193,594,135.46 | 502,596,562.49 |
| 21 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,515,000 | 36,673,956.08 |
| 22 | Урамшуулал | 64,275,834.57 | 69,965,682.26 |
| 23 | Гэрээт ажлын хөлс | | 8,514,387.5 |
| 24 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 166,686,179.62 | 213,650,430.33 |
| 25 | Тэтгэврийн даатгал | 114,927,138 | 161,472,564.3 |

| | | | |
|---|---|---|---|
| 26 | Тэтгэмжийн даатгал | 12,668,213.67 | 10,385,315.75 |
| 27 | ҮОМШӨ-ний даатгал | 10,671,471.88 | 5,645,527.47 |
| 28 | Ажилгүйдлийн даатгал | 2,534,839.97 | 5,383,185.65 |
| 29 | Эрүүл мэндийн даатгал | 25,884,516.1 | 30,763,837.16 |
| 30 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 215,381,816.86 | 276,802,309.97 |
| 31 | Гэрэл, цахилгаан | 17,792,490.86 | 22,739,131.97 |
| 32 | Түлш, халаалт | 179,828,726 | 214,509,978 |
| 33 | Цэвэр, бохир ус | 17,760,600 | 22,753,200 |
| 34 | Байрны түрээс | | 16,800,000 |
| 35 | Хангамж, бараа материалын зардал | 8,832,370 | 58,803,270.96 |
| 36 | Бичиг хэрэг | 252,500 | 1,022,500 |
| 37 | Тээвэр, шатахуун | 5,300,000 | 3,334,900 |
| 38 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,891,270 | 2,501,290.96 |
| 39 | Ном, хэвлэл | | 1,485,000 |
| 40 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,170,800 |
| 41 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 388,600 | 6,174,260 |
| 42 | Бараа материал акталсны зардал | | 43,114,520 |
| 43 | Нормативт зардал | 95,095,404.04 | 115,911,950 |
| 44 | Хоол, хүнс | 94,333,404.04 | 114,206,850 |
| 45 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 762,000 | 1,705,100 |
| 46 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,688,450 | 2,133,700 |
| 47 | Багаж, техник, хэрэгсэл | 412,500 | |
| 48 | Урсгал засвар | 19,275,950 | 2,133,700 |
| 49 | Томилолт, зочны зардал | 790,600 | 1,135,700 |
| 50 | Дотоод албан томилолт | 790,600 | 1,135,700 |
| 51 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,043,330 | 4,926,814 |
| 52 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,643,330 | 1,163,564 |
| 53 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,400,000 | 3,444,000 |
| 54 | Даатгалын үйлчилгээ | | 319,250 |
| 55 | Бараа үйлчилгээний бусад зардал | 154,197,511.34 | 142,927,243.79 |
| 56 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,748,900 | 1,211,250 |

| | | | |
|---|---|---|---|
| 57 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,303,450 | 10,548,522 |
| 58 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 137,145,161.34 | 131,167,471.79 |
| 59 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 168,927,193.78 | 148,292,223.35 |
| 60 | Бусад урсгал шилжүүлэг | 97,143,094 | 76,148,753.75 |
| 61 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 600,000 | 630,800 |
| 62 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,952,800 | 30,217,653.75 |
| 63 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 78,293,294 | 45,300,300 |
| 64 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 297,000 | |
| 65 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 71,784,099.78 | 72,143,469.6 |
| 66 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 71,667,099.78 | 72,134,153.16 |
| 67 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 117,000 | 9,316.44 |
| 68 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -108,987,116.61 | -110,083,183.14 |
| 69 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 223,226 |
| 70 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | | 223,226 |
| 71 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -108,987,116.61 | -110,306,409.14 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

## Мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,060,113,437.00 | 2,643,213,016.44 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 72,167,437 | 54,316,000 |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 72,167,437 | 54,316,000 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 72,167,437 | 54,316,000 |
| 5 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 72,167,437 | 54,316,000 |
| 6 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,987,946,000 | 2,588,897,016.44 |
| 7 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,982,529,000 | 2,563,037,700 |
| 8 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,982,529,000 | 2,563,037,700 |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,417,000 | 25,859,316.44 |
| 10 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 117,000 | |
| 11 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,300,000 | 2,287,896 |
| 12 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 23,571,420.44 |
| 13 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,023,833,087 | 2,627,944,016.44 |
| 14 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,023,833,087 | 2,627,944,016.44 |
| 15 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,855,202,893.22 | 2,479,651,793.09 |
| 16 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,337,121,258.2 | 1,804,680,001.12 |
| 17 | Үндсэн цалин | 637,144,378.8 | 1,101,018,370.94 |
| 18 | Нэмэгдэл | 212,013,869 | 585,499,430.67 |
| 19 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,536,872.19 | 36,521,456.08 |
| 20 | Урамшуулал | 72,644,330.1 | 73,089,983.93 |
| 21 | Гэрээт ажлын хөлс | 390,781,808.11 | 8,550,759.5 |
| 22 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 167,995,413.2 | 232,923,900 |
| 23 | Тэтгэврийн даатгал | 121,005,395.73 | 158,388,200 |
| 24 | Тэтгэмжийн даатгал | 13,138,445.5 | 18,633,900 |
| 25 | ҮОМШӨ-ний даатгал | 9,366,600 | 9,317,000 |
| 26 | Ажилгүйдлийн даатгал | 1,442,771.97 | 9,317,000 |
| 27 | Эрүүл мэндийн даатгал | 23,042,200 | 37,267,800 |
| 28 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 215,249,464.1 | 278,185,309.97 |
| 29 | Гэрэл, цахилгаан | 17,660,138.1 | 22,739,131.97 |
| 30 | Түлш, халаалт | 179,828,726 | 214,509,978 |
| 31 | Цэвэр, бохир ус | 17,760,600 | 24,136,200 |
| 32 | Байрны түрээс | | 16,800,000 |
| 33 | Хангамж, бараа материалын зардал | 3,109,227.72 | 21,360,616 |
| 34 | Бичиг хэрэг | 173,000 | 6,997,200 |
| 35 | Тээвэр, шатахуун | | 3,334,900 |
| 36 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,619,257.72 | 2,905,656 |
| 37 | Ном, хэвлэл | | 1,485,000 |
| 38 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,743,800 |

| | | | |
|---|---|---|---|
| 39 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 316,970 | 4,894,060 |
| 40 | Нормативт зардал | 91,709,750 | 120,929,980 |
| 41 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 400,000 |
| 42 | Хоол, хүнс | 89,981,750 | 118,824,880 |
| 43 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,728,000 | 1,705,100 |
| 44 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,581,700 | 3,249,050 |
| 45 | Багаж, техник, хэрэгсэл | 643,800 | 111,500 |
| 46 | Урсгал засвар | 2,937,900 | 3,137,550 |
| 47 | Томилолт, зочны зардал | 790,600 | 1,135,700 |
| 48 | Дотоод албан томилолт | 790,600 | 1,135,700 |
| 49 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,928,850 | 5,181,014 |
| 50 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,928,850 | 1,417,764 |
| 51 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000 | 3,444,000 |
| 52 | Даатгалын үйлчилгээ | | 319,250 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,716,630 | 12,006,222 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,795,830 | 8,219,400 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 23,920,800 | 3,786,822 |
| 56 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 168,630,193.78 | 148,292,223.35 |
| 57 | Бусад урсгал шилжүүлэг | 96,846,094 | 76,148,753.75 |
| 58 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 600,000 | 630,800 |
| 59 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,952,800 | 30,217,653.75 |
| 60 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 78,293,294 | 45,300,300 |
| 61 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 71,784,099.78 | 72,143,469.6 |
| 62 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 71,667,099.78 | 72,134,153.16 |
| 63 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 117,000 | 9,316.44 |
| 64 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 36,280,350 | 15,269,000 |
| 65 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 36,280,350 | 15,269,000 |
| 66 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 36,280,350 | 15,269,000 |
| 67 | Дотоод эх үүсвэрээр | 36,280,350 | 15,269,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 68 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 36,280,350 | 15,269,000 |
| 69 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -36,280,350 | -15,269,000 |
| 70 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,975,612,137.46 | 799,614,471.51 | -160,502,571.97 | 2,614,724,037 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -1,048,400 | -1,048,400 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,975,612,137.46 | 799,614,471.51 | -161,550,971.97 | 2,613,675,637 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | | | -108,987,116.61 | -108,987,116.61 |
| 5 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,975,612,137.46 | 799,614,471.51 | -270,538,088.58 | 2,504,688,520.39 |
| 6 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,975,612,137.46 | 799,614,471.51 | -270,538,088.58 | 2,504,688,520.39 |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,975,612,137.46 | 799,614,471.51 | -270,538,088.58 | 2,504,688,520.39 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | | | -110,306,409.14 | -110,306,409.14 |
| 9 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 1,975,612,137.46 | 799,614,471.51 | -380,844,497.72 | 2,394,382,111.25 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

# Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | ЗГСУМС гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,610,037,700 | 2,545,219,546.84 | 2,545,219,546.84 | |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,610,037,700 | 2,545,219,546.84 | 2,545,219,546.84 | |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,529,910,200 | 2,469,070,793.09 | 2,469,070,793.09 | |
| 4 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,863,391,000 | 1,804,680,001.12 | 1,804,680,001.12 | |
| 5 | Үндсэн цалин | 1,070,314,700 | 1,101,018,370.94 | 1,101,018,370.94 | |
| 6 | Нэмэгдэл | 574,562,000 | 585,499,430.67 | 585,499,430.67 | |
| 7 | Унаа хоолны хөнгөлөлт | 72,765,100 | 36,521,456.08 | 36,521,456.08 | |
| 8 | Урамшуулал | 145,749,200 | 73,089,983.93 | 73,089,983.93 | |
| 9 | Гэрээт ажлын хөлс | | 8,550,759.5 | 8,550,759.5 | |
| 10 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 232,923,900 | 232,923,900 | 232,923,900 | |
| 11 | Тэтгэврийн даатгал | 158,388,200 | 158,388,200 | 158,388,200 | |
| 12 | Тэтгэмжийн даатгал | 18,633,900 | 18,633,900 | 18,633,900 | |
| 13 | ҮОМШӨ-ний даатгал | 9,317,000 | 9,317,000 | 9,317,000 | |
| 14 | Ажилгүйдлийн даатгал | 9,317,000 | 9,317,000 | 9,317,000 | |
| 15 | Эрүүл мэндийн даатгал | 37,267,800 | 37,267,800 | 37,267,800 | |
| 16 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 279,367,100 | 278,185,309.97 | 278,185,309.97 | |
| 17 | Гэрэл, цахилгаан | 23,685,700 | 22,739,131.97 | 22,739,131.97 | |
| 18 | Түлш, халаалт | 214,510,000 | 214,509,978 | 214,509,978 | |
| 19 | Цэвэр, бохир ус | 24,371,400 | 24,136,200 | 24,136,200 | |
| 20 | Байрны түрээс | 16,800,000 | 16,800,000 | 16,800,000 | |
| 21 | Хангамж, бараа материалын зардал | 17,641,600 | 16,728,616 | 16,728,616 | |
| 22 | Бичиг хэрэг | 7,491,400 | 6,997,200 | 6,997,200 | |
| 23 | Тээвэр, шатахуун | 749,400 | 747,400 | 747,400 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,927,000 | 2,905,656 | 2,905,656 | |
| 25 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,920,000 | 1,743,800 | 1,743,800 | |
| 26 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,553,800 | 4,334,560 | 4,334,560 | |
| 27 | Нормативт зардал | 119,219,700 | 119,218,480 | 119,218,480 | |
| 28 | Хоол, хүнс | 117,514,600 | 117,513,380 | 117,513,380 | |
| 29 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,705,100 | 1,705,100 | 1,705,100 | |
| 30 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,741,600 | 3,741,550 | 3,741,550 | |
| 31 | Багаж, техник, хэрэгсэл | 859,500 | 604,000 | 604,000 | |
| 32 | Урсгал засвар | 2,882,100 | 3,137,550 | 3,137,550 | |
| 33 | Томилолт, зочны зардал | 775,700 | 775,700 | 775,700 | |
| 34 | Дотоод албан томилолт | 775,700 | 775,700 | 775,700 | |
| 35 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,623,900 | 5,606,514 | 5,606,514 | |
| 36 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,858,400 | 1,843,264 | 1,843,264 | |
| 37 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,446,200 | 3,444,000 | 3,444,000 | |
| 38 | Даатгалын үйлчилгээ | 319,300 | 319,250 | 319,250 | |
| 39 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,225,700 | 7,210,722 | 7,210,722 | |
| 40 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,522,600 | 2,507,622 | 2,507,622 | |
| 41 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,703,100 | 4,703,100 | 4,703,100 | |
| 42 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 80,127,500 | 76,148,753.75 | 76,148,753.75 | |
| 43 | Бусад урсгал шилжүүлэг | 80,127,500 | 76,148,753.75 | 76,148,753.75 | |
| 44 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 630,800 | 630,800 | 630,800 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 45 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,196,400 | 30,217,653.75 | 30,217,653.75 | |
| 46 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,300,300 | 45,300,300 | 45,300,300 | |
| 47 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,610,037,700 | 2,545,219,546.84 | 2,545,219,546.84 | |
| 48 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,563,037,700 | 2,490,903,546.84 | 2,490,903,546.84 | |
| 49 | Улсын төсвөөс санхүүжих | 2,563,037,700 | 2,490,903,546.84 | 2,490,903,546.84 | |
| 50 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 47,000,000 | 54,316,000 | 54,316,000 | |
| 51 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 47,000,000 | 54,316,000 | 54,316,000 | |
| 52 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 147 | 151 | | 151 |
| 53 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | 1 |
| 54 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 1 |
| 55 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 73 | 75 | | 75 |
| 56 | Удирдах ажилтан | 2 | 2 | | 2 |
| 57 | Гүйцэтгэх ажилтан | 50 | 46 | | 46 |
| 58 | Үйлчлэх ажилтан | 21 | 27 | | 27 |
| 59 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 73 | 75 | | 75 |
| 60 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1 | 1 | | 1 |
| 61 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 46 | 46 | | 46 |
| 62 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 | | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 63 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 25 | 27 | | 27 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн үйл ажиллагааны чиглэл:***

- *Боловсролын үйл ажиллагаа*

***Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн зорилго**: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэж хөдөлмөр эрхлэлийг дэмжих зарчмаар сургалтын агуулга хөтөлбөрийг сайжруулах Бaшгийн гурван тулгуурт бодлого цогц арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэн хөгжүүлэх салбар дундын дадлагын бааз байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгыг дэвжүүлж байна..*

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:**

1. Боловсролын ерөнхий хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай  хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.  Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Сургуулийн захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

***Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн*** 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

***Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн*** 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос **104,939.08** мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 16,537.4 | 18,610.8 | 2,073.4 |
| Бараа материал | 369,866.5 | 335,443.8 | -34,422.7 |
| Үндсэн хөрөнгө | 2,153,010.7 | 2,080,420.9 | -72,589.8 |
| **Нийт хөрөнгө** | **2,539,414.6** | **2,434,475.6** | **-104,939.0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,504,688.5 | 2,394,382.1 | -110,306.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,539,414.6** | **2,434,475.6** | **-104,939.0** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл 16,537.4 мянган төгрөг, 2,073.4 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 18,610.8 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 369,866.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 137,356.2 хандив тусламжаар 3,881,6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 175,660.5 зарцуулж эцсийн үлдэгдэл 335,443.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,422.7 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,563,037.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 47,000.0 нийт зарлагыг 2,610,037.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,610,037.70 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,545,219.55 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71802** | **Ерөнхий боловсрол** | | | | |
| 80101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,863,391.0 | 1,804,680.0 | 58,710.9 | 96.85 |
| 80101 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 232,923.9 | 232,923.9 | 0.00 | 100.00 |
| 81801 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 279,367.1 | 278,185.3 | 1,181.7 | 99.58 |
| 80101 | Хангамж, бараа материалын зардал | 17,641.6 | 16,728.6 | 912.9 | 94.82 |
| 80101 | Нормативт зардал | 1,705.1 | 1,705.1 | 0.00 | 100.00 |
| 81801 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,741.6 | 3,741.6 | 0.00 | 100.00 |
| 80101 | Томилолт, зочны зардал | 775.7 | 775.7 | 0.00 | 100.00 |
| 80101 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,623.9 | 5,606.5 | 17.3 | 99.69 |
| 81801 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,225.7 | 7,210.7 | 14.9 | 99.79 |
| 80802 | Бусад урсгал шилжүүлэг | 80,127.5 | 76,148.7 | 3,978.7 | 95.03 |
| 81806 | Хоол, хүнс/Дотуур байр/ | 117,514.6 | 117,513.3 | 1.2 | 100.00 |
| | **Нийт дүн** | **2,610,037.70** | **2,545,219.55** | **64,818.15** | **97.5** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 25,859.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс Гүйцэтгэлээр 2,587.5 мянган төгрөгийг тээвэр шатахуун, 9,316,4 мянган төгрөгийг урсгал засвар, 360.0 мянган төгрөгийг дотоод албан томилолт, 13,434,7 мянган төгрөгийг биет болон биет ус хөрөнгө худалдан авах зардал, 5,711.7 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

**Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авах ажиллагааг тендер зарлаагүй шууд гэрээ байгуулж ажилласан байна.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу

Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит ХХК"-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд нар хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежи нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугээр сарын 18-ны өдрийн 1/16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 2,801,269.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 56,025.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 44,820.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, санхүүгийн үр дүнгийн тайлан өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 2,801,269.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 56,025.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 44,820.2 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн хөгжим бүжгийн коллежийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж албан хаагчийн цалин, ээлжийн амралтын цалинг давхардуулан олгосон, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн тэг үлдэгдэлтэй байгаа хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгаагүй зэрэг зөрчлүүд илэрч зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 316,311.9 мянган төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 2 төлбөрийн акт өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 891.3 | 2 | 891.3 | 100% |
| Албан шаардлага | 8 | 315,420.6 | 7 | 242,454.2 | 90% |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **10** | **316,311.9** | **9** | **243,345.5** | **95%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллага нь нягтлан бодогчоо тогтвор суурьшилтай ажиллуулж, нягтлан бодох бүртгэл,дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,340.2 мянган төгрөгийн алдаа илэрч, 14,105.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,234.6 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүллээ.

***Залруулсан алдаа:*** *Мөнгөн сууриар илэрхийлж шууд зардалд бичилт хийсэн 80,160.3 мянган төгрөгийн 6 алдааг тайланд залруулсан.*

### 5.1 Төлбөрийн акт:

- ***Илэрсэн алдаа:*** Албан хаагчийн ээлжийн амралтын цалинг 257.6 мянган төгрөгийн зөрүүтэй тооцож олгосон, дотуур байрны хүнсний материалын үлдэгдэл 443.4 мянган төгрөгөөр дутагдсан, үйлчилгээний ажилчдад 1,800.0 мянган төгрөгөөр ажлын хувцас худалдан авсан, он дамжсан 11,604.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

- ***Шийдвэрлэсэн нь:*** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-т “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 6.4.8-д “төсвийг зохистой

удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэж заасныг тус тус зөрчсөнд 14,105.6 мянган төгрөгийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

## 5.3 Зөвлөмж:

- ***Илэрсэн алдаа:*** Хүүхдийн хоолыг нормативт зардлаас 5,234.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.
- **Зөвлөмж өгсөн:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

- ***Илэрсэн алдаа:*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 210 төрлийн 377,515.6 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ***Өгсөн зөвлөмж***: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;
-
- ***Илэрсэн алдаа:*** Хандив тсламжаар үнэ төлбөргүй ирсэн 15 ширхэг зөөврийн компьютерийг орлогод аваагүй, Швейцарын хөрөнгө оруулалтаар ирсэн хөгжим аппартур тоног төхөөремжийг эргэлтийн хөрөнгөд орлого авсан.
- **Зөвлөмж өгсөн:**ТБОНӨ-ийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 "үндсэн хөрөнгөнд гарсан хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник технологийн баримт бичгийг гүйцэт бүрдүүлсэн байх", НББ-ийн тухай хууулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтуудыг зөрчсөн байна.
- ***Илэрсэн алдаа:*** Улиастай сумын ОНХС-аас олгосон 20,000.0 мянган төгрөгийг данс бүртгэлээр дамжуулалгүй зарцуулсан.
- **Зөвлөмж өгсөн:** Төсвийн тухай хуулийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай

хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн сууриар илэрхийлж шууд зардалд бичсэн | 6 | 80,160.3 | | | 6 | 80,160.3 | 6 | 80,160.3 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **6** | **80,160.3** | | | **6** | **80,160.3** | **6** | **80,160.3** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн зөрүүг суутгаагүй | 1 | 257.6 | 1 | 257.6 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүнсний материалын үлдэгдэл дутагдсан | 1 | 443.4 | 1 | 443.4 | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж ажлын хувцас олгосон | 1 | 1,800.0 | 1 | 1,800.0 | | | | | | | | |
| Өмнөх оны аудитын албан шаардлагаар өгсөн авлагыг барагдуулаагүй | 1 | 11,604.5 | 1 | 11,604.5 | | | | | | | | |
| Дотуур байрны хүүхдийн хоолыг нормативт зардлаас дутуу олгосон. | 1 | 5,234.6 | | | | | 1 | 5,234.6 | | | | |
| Мобикомоос олгогдсон үнэ төлбөргүй 15 ш зөөврийн компьютерийг орлогод авах / 2022 онд ирсэн / | 1 | | | | | | 1 | | | | | |
| 2023 онд Швейцарын хөрөнгө оруулалтаар ирсэн хөгжим аппартур тоног төхөөрөмжийг эргэлтийн хөрөнгөд авсан 141,900,000.00 | 1 | | | | | | 1 | | | | | |
| ОНХС-аас шийдвэрлэсэн хөрөнгийг данс бүртгэлээр дамжуулалгүй зарцуулсан /20000000 / | 1 | | | | | | 1 | | | | | |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 210 нэр төрлийн 377,515,590.75 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | | **19,340.2** | **4** | **14,105.6** | | | **5** | **5,234.6** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-22

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-02-22